



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/17/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Даланзадгад хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.02.23 № 96  
тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН  
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Т.ЭНХТУЯА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн биеийн тамир, спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өмнөговь аймгийн биеийн тамир, спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг дутагдуулсан, ээлжийн амралтын урамшууллыг үндэслэлгүйгээр олгосон нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.4, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.9 дэх заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 14/11 дугаар тогтоолоор баталсан "Өмнөговь аймгийн соёл, урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив

016020181

дэлхийн чанартай тэмцээн уралдаанд амжилт гаргасан уран бүтээлч, тамирчинд шагнал олгох журам"-ийн дагуу улс, орон нутаг, олон улсын тэмцээнд амжилт гаргасан 29 тамирчин, мэргэжлийн 3 холбоо, 4 дасгалжуулагч, 2 шилдэг багийг тус тус шалгаруулж 52,580,000 төгрөгийн мөнгөн шагнал олгосон байна.

#### **Аудитын гол асуудал**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж 2021 онд ашиглалтад оруулсан 3,966,524,072 төгрөгийн өртөгтэй Соёл, спорт цогцолборын барилгыг 2022 онд ашиглалтад өгсөн улсын комиссын актыг үндэслэн дуусаагүй барилга, байгууламжийн данснаас барилга байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгэж санхүүгийн тайланд толилуулсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аймгийн Засаг даргын 2023 оны А/471 дугаар захирамжаар Өмнөговь аймгийн үндэсний бөхийн дасгалжуулагчдыг томилж, Засаг даргын ангилалдаагүй бусад нөөц хөрөнгийн Үндэсний болон орон нутгийн онцлогтой бусад спортыг хөгжүүлэх зардлаас гэрээ байгуулан цалинжуулж ажилласан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>133,642,407.30</u></b>	<b><u>141,505,906.71</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	19,149,699.41
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,349,699.41
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	17,800,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	17,800,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	32,660,000.00	600,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	32,060,000.00	-
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	600,000.00	600,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	600,000.00	600,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	100,982,407.30	121,756,207.30
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	78,266,633.70	98,676,733.70
35110	Тусгай зориулалттай материал	77,890,228.70	98,300,328.70
35130	Эм боох материал	376,405.00	376,405.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	22,715,773.60	23,079,473.60
35410	Бичиг хэргийн материал	5,143,925.00	3,500,425.00
35420	Аж ахуйн материал	14,288,348.60	16,560,548.60
35430	Сэлбэг хэрэгсэл	80,000.00	80,000.00
35450	Барилгын засварын материал	3,203,500.00	2,938,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>8,583,220,393.26</u></b>	<b><u>8,932,842,047.02</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	8,583,220,393.26	8,932,842,047.02
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	7,474,052,603.26	7,813,530,037.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,084,678,169.85	17,377,527,208.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,146,852,566.11)	(10,534,541,988.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,050,000.00	254,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,050,000.13)	(31,172,916.85)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	396,641,443.82	677,002,143.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(167,227,343.00)	(249,369,358.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	423,987,336.90	472,577,336.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(152,348,510.07)	(200,542,389.52)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,000,000.00	5,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,650,000.00	42,650,000.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	3,966,524,072.00	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,109,167,790.00	1,119,312,009.99
39301	Програм хангамж	5,498,900.00	16,998,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,505,910.00)	(3,861,690.01)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,106,174,800.00	1,106,174,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>8,716,862,800.56</u></b>	<b><u>9,074,347,953.73</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>1,349,699.41</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	1,349,699.41
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	1,349,699.41
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	1,349,699.41
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,349,699.41
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>8,716,862,800.56</u></b>	<b><u>9,072,998,254.32</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,716,862,800.56	9,072,998,254.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,753,651,326.10	5,753,651,326.10
51101	Өмч: - төрийн	5,753,651,326.10	5,753,651,326.10

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	724,332,831.49	1,080,468,285.25
51210	Өмнөх үеийн үр дүн	724,332,831.49	658,224,096.49
51220	Тайлант үеийн үр дүн	-	422,244,188.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,238,878,642.97	2,238,878,642.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,716,862,800.56</b>	<b>9,074,347,953.73</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>996,470,320.00</b>	<b>1,445,535,596.88</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>996,470,320.00</b>	<b>1,445,535,596.88</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	404,903,900.00	689,158,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	404,903,900.00	689,158,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	159,019,920.00	414,003,396.88
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	122,229,920.00	377,995,708.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,780,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,790,000.00	29,227,688.88
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	432,546,500.00	342,373,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	432,546,500.00	342,373,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,322,004,782.77</b>	<b>1,789,546,275.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,322,004,782.77</b>	<b>1,789,546,275.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,128,923,342.38	1,506,064,742.79
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	297,509,351.57	431,431,680.46
210101	Үндсэн цалин	215,306,302.43	308,597,524.69
210102	Нэмэгдэл	22,710,258.14	44,186,968.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,147,522.86	54,572,033.09
210104	Урамшуулал	15,345,268.14	24,075,154.51
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,277,358.27	37,232,065.38
210201	Тэтгэврийн даатгал	25,348,635.66	22,225,163.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,982,180.62	3,717,476.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,385,724.52	3,195,412.10
210204	Ажилгүйдлийн даатгал	596,456.10	688,705.73
210205	Эрүүл мэндийн даатгал	5,964,361.37	7,405,306.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	130,408,453.77	140,714,757.71
210301	Гэрэл, цахилгаан	62,739,503.17	57,169,850.03
210302	Түлш, халаалт	40,697,254.60	60,523,576.68
210303	Цэвэр, бохир ус	26,971,696.00	23,021,331.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	39,824,265.40	19,098,201.00
210401	Бичиг хэрэг	2,312,850.00	1,013,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,333,900.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,464,300.00	1,533,001.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,766,940.90	599,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,942,600.00	3,487,000.00
210408	Бараа материал акталсны зардал	28,003,674.50	9,965,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>29,042,500.00</b>	<b>43,150,250.00</b>
210604	Урсгал засвар	29,042,500.00	43,150,250.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,841,500.00</b>	<b>2,177,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,841,500.00	2,177,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,045,256.00</b>	<b>6,333,130.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,430,000.00	1,022,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	407,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	380,756.00	429,200.00
210807	Газрын төлбөр	2,084,500.00	4,419,680.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>586,974,657.37</b>	<b>825,927,658.24</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	188,620,731.00	357,532,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,902,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	396,451,926.37	468,395,278.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>193,081,440.39</b>	<b>283,481,532.33</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,893,821.00</b>	<b>118,277,462.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,893,821.00	118,277,462.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>72,279,489.16</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	72,279,489.16
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>176,187,619.39</b>	<b>92,924,581.17</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	176,187,619.39	92,924,581.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(325,534,462.77)</b>	<b>(344,010,678.24)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(325,534,462.77)</b>	<b>(344,010,678.24)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>996,470,320.00</b>	<b>1,445,535,596.88</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>996,470,320.00</b>	<b>1,445,535,596.88</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	404,903,900.00	689,158,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	404,903,900.00	689,158,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	159,019,920.00	414,003,396.88
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	122,229,920.00	377,995,708.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,780,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,790,000.00	29,227,688.88
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	432,546,500.00	342,373,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	432,546,500.00	342,373,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>960,065,620.00</b>	<b>1,338,804,796.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>960,065,620.00</b>	<b>1,338,804,796.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>766,984,179.61</b>	<b>1,055,323,264.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	297,509,351.57	431,431,680.46
210101	Үндсэн цалин	215,306,302.43	308,597,524.69
210102	Нэмэгдэл	22,710,258.14	44,186,968.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,147,522.86	54,572,033.09
210104	Урамшуулал	15,345,268.14	24,075,154.51
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,277,358.27	37,232,065.38
210201	Тэтгэврийн даатгал	25,348,635.66	22,225,163.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,982,180.62	3,717,476.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,385,724.52	3,195,412.10
210204	Ажилгүйдлийн даатгал	596,456.10	688,705.73
210205	Эрүүл мэндийн даатгал	5,964,361.37	7,405,306.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	130,408,453.77	140,714,757.71
210301	Гэрэл, цахилгаан	62,739,503.17	57,169,850.03
210302	Түлш, халаалт	40,697,254.60	60,523,576.68
210303	Цэвэр, бохир ус	26,971,696.00	23,021,331.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,594,100.00	9,132,601.00
210401	Бичиг хэрэг	1,372,800.00	1,013,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,860,000.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,464,300.00	1,533,001.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,000.00	599,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,325,000.00	3,487,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	71,130,900.00	70,769,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	19,369,500.00
210602	Тавилга	-	
210604	Урсгал засвар	71,130,900.00	51,400,150.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	2,841,500.00	2,177,000.00
210702	Дотоод албан томиллолт	2,841,500.00	2,177,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,045,256.00	6,333,130.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,430,000.00	1,022,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	407,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	380,756.00	429,200.00
210807	Газрын төлбөр	2,084,500.00	4,419,680.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	213,177,260.00	357,532,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	211,275,260.00	357,532,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,902,000.00	-

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193,081,440.39	283,481,532.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,893,821.00	118,277,462.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,893,821.00	118,277,462.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,593,998.17	72,279,489.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,593,998.17	72,279,489.16
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	143,342,386.22	92,924,581.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	143,342,386.22	92,924,581.17
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,251,235.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,251,235.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>36,404,700.00</u>	<u>106,730,800.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	36,404,700.00	106,730,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,404,700.00	106,730,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,404,700.00	106,730,800.00
223001	Бусад хөрөнгө	36,404,700.00	106,730,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(36,404,700.00)</u>	<u>(106,730,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,753,651,326.10	2,238,878,642.97	724,332,831.49	8,716,862,800.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(66,108,735.00)	(66,108,735.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			(66,108,735.00)	(66,108,735.00)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			422,244,188.76	422,244,188.76
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,753,651,326.10	2,238,878,642.97	1,080,468,285.25	9,072,998,254.32

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,031,533,200.00	871,454,218.55
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,031,533,200.00	871,454,218.55
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,028,733,200.00	870,434,764.55
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	445,090,800.00	401,431,680.46
210101	Үндсэн цалин	273,911,800.00	278,597,524.69
210102	Нэмэгдэл	74,327,400.00	44,186,968.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,132,000.00	54,572,033.09
210104	Урамшуулал	35,719,600.00	24,075,154.51
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,636,300.00	37,232,065.38
210201	Тэтгэврийн даатгал	37,832,700.00	22,225,163.84
210202	Тэтгэмжийн даатгал	4,450,900.00	3,717,476.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,560,700.00	3,195,412.10
210204	Ажилгүйдлийн даатгал	890,200.00	688,705.73
210205	Эрүүл мэндийн даатгал	8,901,800.00	7,405,306.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	201,763,200.00	140,714,757.71
210301	Гэрэл, цахилгаан	73,410,300.00	57,169,850.03
210302	Түлш, халаалт	104,368,600.00	60,523,576.68
210303	Цэвэр, бохир ус	23,984,300.00	23,021,331.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,336,000.00	9,132,601.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,013,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,536,000.00	1,533,001.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	599,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	3,487,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	206,411,200.00	177,500,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,800,000.00	43,643,300.00
210602	Тавилга	20,000,000.00	19,997,000.00
210604	Урсгал засвар	140,611,200.00	113,860,150.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	2,500,000.00	2,177,000.00
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	2,177,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,220,500.00	6,333,130.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	1,022,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	407,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,500.00	55,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	429,200.00
210807	Газрын төлбөр	4,800,000.00	4,419,680.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	98,775,200.00	95,913,080.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,775,200.00	95,913,080.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,800,000.00	1,019,454.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,800,000.00	1,019,454.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	1,019,454.00

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,031,533,200.00	871,454,218.55
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	689,158,800.00	616,879,310.84
131001	Улсын төсвөөс санхүүжих	689,158,800.00	616,879,310.84
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	342,374,400.00	254,574,907.71
132001	Орон нутгийн төсвөөс	342,374,400.00	254,574,907.71

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>414,003,396.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>414,003,396.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	291,619,300.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	30,000,000.00
210101	Үндсэн цалин	30,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	261,619,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	261,619,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	117,258,008.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	117,258,008.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	117,258,008.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,126,088.88</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5,126,088.88
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	414,003,396.88
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	414,003,396.88
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	377,995,708.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,780,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,227,688.88
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,167,116.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 4,167,116.6 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсөвт татан төвлөрүүлсэн 70,929.8 мянган төгрөгийн шилжүүлгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулаагүй, зарлагын дүнд тохируулах бичилт хийгээгүй тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 113,625.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж тайлагнаагүй,
- Дуусаагүй барилга, байгууламжийн дансанд үлдэгдэлтэй байсан 3,966,524.1 мянган төгрөгийн өртөгтэй Спорт цогцолборын барилгыг барилга байгууламжийн дансанд шилжүүлж авахдаа данснаас хасаж орлого үр дүнгийн тайланд гарзаар тайлагнасан,
- Орлого үр дүнгийн тайланд цалин, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, шуудан холбоо, хог хаягдал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг тус тус зөрүүтэй илэрхийлсэн байна. /нийт 3,307.1 мянган төгрөг/
- Байгууллагын даргын 2023 оны А/102 дугаар тушаалаар цаашид ашиглах боломжгүй 31 нэр төрлийн 12,729.9 мянган төгрөгийн дансны үнэтэй эргэлтийн хөрөнгийг данснаас хасах шийдвэр гарсан боловч нягтлан бодох бүртгэлд тусгаж ажиллаагүй байна

Аудитаар нийт 125,154.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 22,831.2 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 47,056.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 55,267.0 мянган төгрөгийн зөрчилд хууль тогтоомжтой холбоотой 3 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

Байгууллагын даргын 2023 оны Б/10 дугаар тушаалаар тус газрын нягтлан бодогч ажилтай Г.Алимааг чөлөөлсөнтэй холбогдуулж эд хөрөнгийн тооллого явуулахад нягтлан бодогчийн нэр дээр данслагдсан 6 нэр төрлийн 5,031.2 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө дутагдсан зөрчлийг арилгуулаагүй, тус хөрөнгүүд байгууллага дээр биетээр байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3 "агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах", санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

2022 онд гэрээ байгуулсан "Спорт заалны хүндэтгэлийн хана хийх угсрах" 17,800.0 мянган төгрөгийн ажлын гэрээний хэрэгжилтийг хангуулаагүй, 2023 оны 02 сарын 24-ны өдрийн 08/А1670364 ӨМА-2023/42/НА-СТА-ТШЗ дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгийг буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

### **3.2 Албан шаардлага**

Аймгийн Засаг даргын 2023 оны А/2527 дугаар захирамж, байгууллагын даргын 2023 оны Б/06, Б/22, Б/23, Б/24 дугаар тушаалаар тус тус ажлын зайлшгүй шаардлагаар ажилласан эсэх нь тодорхойлогдохгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн 5 албан хаагчид ээлжийн амралтын урамшуулалд 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх 7,056.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулалд олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.9 "ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн урсгал засвар болон шинээр хөрөнгө хүлээн авахдаа байнгын ашиглалтад хүлээх авах комиссын бүрэлдэхүүнийг томилоогүй, байгууллагын дарга, нягтлан гарын үсэг зурж, хүлээн авсан комиссын акт үйлдээгүй, гэрээг дүгнэж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.10.1.4 "захиалагч нь худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулах замаар бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, энэ журмын 9 болон 13 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана", хавсралт маягт 6,15,16-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Аймгийн засаг даргын 2023 оны А/1083 дугаар захирамжаар Баянхонгор аймагт зохион байгуулагдах Монголын хүүхдийн VII наадамд Өмнөговь аймгаас оролцох баг тамирчдын нэгдсэн хувцас, хоол унаа болон бусад зардалд зориулан олгосон Засаг даргын нөөц хөрөнгөөс 40,000.0 мянган төгрөгийн "Хээрийн бэлтгэлд хамруулах сууц, хоол хувцсаар хангах, унаагаар үйлчилгээ үзүүлэх ажил"-ын гэрээг Оюуны самбар НҮТББ-тай шууд гэрээ байгуулж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

**Илрүүлэлт:**1 Байгууллагын даргын 2023 оны А/100 дугаар тушаалаар "Саммит компьютер технологи" ХХК-аас 18,539.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, А/103 дугаар тушаалаар "Өрнүүн говь" ХХК-аас 17,842.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, А/104 дүгээр тушаалаар "Хүч-Ингүүмэл" ХХК-аас 18,886.0 мянган төгрөгийн спортын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг худалдан авахдаа цахим дэлгүүрт байршсан эсэхийг тодорхойлоогүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлж, цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх

**Илрүүлэлт: 2** Тус байгууллага нь бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"-д заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах

**Илрүүлэлт:3** Тайлан онд "Саммит компьютер технологи" ХХК, "Өрнүүн говь" ХХК, "Хүч-Ингүүмэл" ХХК, Анисфарм ХХК болон урсгал завсар гүйцэтгэсэн аж ахуй нэгж, иргэдтэй гэрээ байгуулахдаа чөлөөт өрсөлдөөнөөр сонгон шалгаруулалт хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 "албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгож ажиллах зөвлөмж хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсны төсөвт татан төвлөрүүлсэн шилжүүлгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулаагүй, зарлагын дүнд тохируулах бичилт хийгээгүй тайлагнасан байна.	1	70,929.7			1	70,929.7	1	70,929.7				
Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 113,625.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж тайлагнаагүй байна.	1	113,625.8			1	113,625.8	1	113,625.8				
Дуусаагүй барилга, байгууламжийн дансанд үлдэгдэлтэй байсан 3,966,524.0 мянган төгрөгийн өртөгтэй Спорт цогцолборын барилгыг барилга байгууламжийн дансанд шилжүүлж авахдаа данснаас хасаж орлого үр дүнгийн тайланд гарзаар тайлагнасан байна.	1	3,966,524.0			1	3,966,524.0	1	3,966,524.0				
Орлого үр дүнгийн тайланд цалин, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, шуудан холбоо, хог хаягдал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг тус тус зөрүүтэй илэрхийлсэн байна. /нийт 3,307.0 мянган төгрөг/	1	3,307.0			1	3,307.0	1	3,307.0				
Байгууллагын даргын 2023 оны А/102 дугаар тушаалаар цаашид ашиглах боломжгүй 31 нэр төрлийн 12,729.9 мянган төгрөгийн дансны үнэтэй эргэлтийн хөрөнгийг данснаас хасах шийдвэр гарсан боловч нягтлан бодох бүртгэлд тусгаж ажиллаагүй байна.	1	12,729.9			1	12,729.9	1	12,729.9				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>4,167,116.6</b>			<b>5</b>	<b>4,167,116.6</b>	<b>5</b>	<b>4,167,116.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн
Тус байгууллага нь бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.	1	0					1	0				
Байгууллагын даргын 2023 оны Б/10 дугаар тушаалаар тус газрын нягтлан бодогч ажилтай Г.Алимааг чөлөөлсөнтэй холбогдуулж эд хөрөнгийн тооллого явуулахад нягтлан бодогчийн нэр дээр данслагдсан 6 нэр төрлийн 5,031,2 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө дутагдсан зөрчлийг арилгуулаагүй, тус хөрөнгүүд байгууллага дээр биетээр байхгүй байна.	1	5,031.2	1	5,031.2								
Аймгийн Засаг даргын 2023 оны А/2527 дугаар захирамж, байгууллагын даргын 2023 оны Б/06, Б/22, Б/23, Б/24 дугаар тушаалаар тус тус ажлын зайлшгүй шаардлагаар ажилласан эсэх нь тодорхойлогдохгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн 5 албан хаагчид ээлжийн амралтын урамшуулалд 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх 7,056.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгож ажилласан байна.	1	7,056.0			1	7,056.0						
Тайлан онд "Саммит компьютер технологи" ХХК, "Өрнүүн говь" ХХК, "Хүч-Ингүүмэл" ХХК, Анисфарм ХХК болон урсгал завсар гүйцэтгэсэн аж ахуй нэгж, иргэдтэй гэрээ байгуулахдаа чөлөөт өрсөлдөөнөөр сонгон шалгаруулалт хийгээгүй байна	1	-					1	0				
Барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн урсгал засвар болон шинээр хөрөнгө хүлээн авахдаа байнгын ашиглалтад хүлээх авах комиссын бүрэлдэхүүнийг томилоогүй, байгууллагын дарга, нягтлан гарын үсэг зурж,	1	-			1	0						

хүлээн авсан комиссын акт үйлдээгүй, гэрээг дүгнэж ажиллаагүй байна.												
Аймгийн засаг даргын 2023 оны А/1083 дугаар захирамжаар Баянхонгор аймагт зохион байгуулагдах Монголын хүүхдийн ҮИИ наадамд Өмнөговь аймгаас оролцох баг тамирчдын нэгдсэн хувцас, хоол унаа болон бусад зардалд зориулан олгосон Засаг даргын нөөц хөрөнгөөс 40,000,000 төгрөгийг "Хээрийн бэлтгэлд хамруулах сууц, хоол хувцсаар хангах, унаагаар үйлчилгээ үзүүлэх ажил"-ын гэрээг Оюуны самбар НҮТББ-тай шууд гэрээ байгуулж ажилласан байна.	1	40,000.0			1	40,000.0						
2022 онд гэрээ байгуулсан "Спорт заалны хүндэтгэлийн хана хийх угсрах" 17,800,000 төгрөгийн ажлын гэрээний хэрэгжилтийг хангуулаагүй, 2023 оны 02 сарын 24-ны өдрийн 08/А1670364 ӨМА-2023/42/НА-СТА-ТШЗ дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгийг буцаан төвлөрүүлээгүй байна	1		1	17,800.0								
Байгууллагын даргын 2023 оны А/100 дугаар тушаалаар "Саммит компьютер технологи" ХХК-аас 18,539,000 төгрөгийн тоног төхөөрөмж, А/103 дугаар тушаалаар "Өрнүүн говь" ХХК-аас 17,842,000 төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, А/104 дүгээр тушаалаар "Хүч-Ингүүмэл" ХХК-аас 18,886,000 төгрөгийн спортын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг худалдан авахдаа цахим дэлгүүрт байршсан эсэхийг тодорхойлоогүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	55,267.0					1	55,267.0				
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>125,154.2</b>	<b>2</b>	<b>22,831.2</b>	<b>3</b>	<b>47,056.0</b>	<b>3</b>	<b>55,267.0</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны системд 9 мэдээлэл хоцруулсан, 8,9 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 162,032,574.57 төгрөгийн 14 ажил гүйлгээг мэдээлээгүй, хөрөнгө зарцуулсан шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээг хугацаа хоцруулан нөхөж мэдээлсэн, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг байршуулаагүй байна.	1	162,032.6			1	162,032.6		
ДҮН	1	162,032.6			1	162,032.6		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Төсвийн шууд захирагч	1	1				1		
	<b>НИЙТ</b>								